



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/87

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Т.Хишигбаатар –Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: С.Байгалмаа – Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

П.Отгонбаяр – Төрийн захиргааны, удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Л.Мандал – Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Наранбаяр- Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Э.Ганзориг– Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

У.Балжинням – Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Алтангэрэл – Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга

Т.Норовринчин - Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

601220203

2.


Д.Туяадэлгэр – Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ч.Дуламсүрэн – Баянхонгор сумын 10 дугаар багийн иргэн / Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл/

Нарийн бичгийн дарга: Н.Жаргалмаа- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах” ажлын хэсгийн тайланг 06 дугаар сарын 25-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, эрэмбэлэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах ажлын хэсэгт хяналт тавьж ажиллахыг орлогч (Б.Батсуурь)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН